

МОНГОЛ-GERМАНЫ ТҮРҮҮ ҮЕИЙН ХАРИЛЦАА

Д. УЛАМБАЯР

XIX зууны эцэст дэлхийг хуваан эзэгнэх явдал төгсгөлдөө ойртож, түүнийг дахин хуваарилах, нөлөөний хүрээгээ өргөтгөх өрсөлдөөнт тэмцэл ялангуяа Алс дорнодод нэн хурцдав. Хэрэг дээрээ хагас колони болж хувирсан Манж Чин улсын сүүлчийн улирал хуучин болон шинээр төрж гарсан их гүрнүүд Монгол орныг өөр, өөрийн нөлөөний хүрээнд оруулахаар өрсөлдөж байх зуур тус орон дэлхийн капиталист зах зээлийн хүрээнд улам бүр татагдан орж, олон улсын капиталын урсгал Монгол газар цутган орж эдийн засгийн тэмцэл нэн хүчтэй явагдах болжээ.

Богино хугацаанд хүчирхэг гүрэн болсон Япон улсын зүүн Азийн эх газар дахь ашиг сонирхол нь Хаант Оросын болон Германы мөн тийм ашиг сонирхолтой мөргөлдөх болов. 1886 онд Москвад Хаант Орос, Чин улстай Японы эсрэг харилцан туслалцах гэрээ байгуулах дашрамд 1891 оноос барьж эхэлсэн Сибирийн төмөр замын үргэлжлэл Дорнод Хятадын төмөр замыг Манжуурын нутгаар цэргийн тусгай хамгаалалт, онцгой дэглэм бүхий зурвас газарт тавих эрх олж авчээ. Хоёр жилийн дараа Хаант Орос, Герман хоёр далд дипломатаар үгсэн нийлж Герман нь Шаньдунгийн өмнөд эргийн Киа-Чаог(Цзяочжоу), Орос нь Порт-Артур, Ляодунгийн хойгийг олон жилээр түрээслэн авах гэрээг Хятадад тулган хүлээлгэжээ. Мөн 1898 онд Шаньдун муж ба Шар мөрний сав газар төмөр зам барих Германы онц эрхийг Англи хүлээн зөвшөөрсний хариуд Хөх мөрөн болон Шаньси мужид Английн тийм эрхийг Герман ч хүлээн зөвшөөрсөн байна. Мөн Орос-Английн 1899 оны хэлэлцээрээр Орос улс Хөх мөрний сав газарт, Англи нь Их цагаан хэрмээс хойшхи нутагт төмөр зам тавих концесс шаардахгүй байх үүрэг авчээ.

Энэ үед Хятадын Шаньдун мужид эхэлсэн түүхнээ Ихэтуаны гэж нэрлэгдсэн олон түмний хүчтэй бослогыг Германы империйн маршал Альфред фон Валдерсийн удирдлагын дор Англи, Орос, Франц, Япон, Америк, Бельги зэрэг их гүрнүүдийн цэрэгтэй хамтран нэгдсэн хүчээр даржээ.

XIX зууны сүүлчээр Герман Алс Дорнодын Солонгос, Япон, Чин улстай найрамдал, худалдааны хэлэлцээрийг нэгэнт байгуулаад байв. Чухамхүү өгүүлэн буй энэ үеэс Германы Алс Дорнодын ашиг сонирхол бий болж, улмаар Монголд ч анхаарал тавих болсон байна.

* Д.Уламбаяр - МУИС-ийн Олон улсын харилцааны сургуулийн багш, доктор (Ph.D)

Их гүрнүүд Монгол орныг зөвхөн бараа, таваар борлуулах, капитал оруулах уужим зах зээлийн төдийгөөр зогсохгүй өргөн уудам нутгийг нь стратегийн түшиц газар болгон арвин их баялгийг нь талан эзэмшихийг эрмэлзэж байв. Монголын ард түмнийг үйлдвэрийн аар саар бараагаар хуурч, тус орны түүхий эдийг хямд үнээр сул шахам завшиж газар орны баялгийг нь тонон ашиглах талаар Хятадын худалдаа мөнгө хүүлэхийн капитал, Оросын худалдаачидтай Герман, Англи, Америк, Японы капитал нэмж өрсөлдөх болжээ. Их гүрнүүдийн хагас колони болсон Чин улсын засгийн газар “шинэ засгийн бодлого” гэгчийг явуулж, тус орныг хятадын зах хязгаар болгож, бүр мөсөн зээрхэхэд чиглэсэн улс төр, эдийн засаг, цэргийн арга хэмжээ авч, түүнээ хүчээр тулган хэрэгжүүлэх болсон нь Монголын нийгмийн бүх давхаргын дургүйцлийг туйлд нь хүргэж, Чин улсаас өрх тусгаарлах эрх чөлөөний хөдөлгөөнийг эрчимтэй өрнөхөд хүргэв.

1911 оны эцсээр Монголчуудын үндсээ чөлөөлөх тэмцэл Хаант Оросын дэмжлэг олж, улмаар ялалтанд хүрч Чин улсын ноёрхлыг эцэс болгосноор тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж шашин, төрийг хослон баригч Богд хаант Монгол улсын Засгийн газрыг дотоод, гадаад, цэрэг, сан, шүүх гэсэн 5 яамтайгаар байгуулан 1911 оныг “Олноо өргөгдсөний” тэргүүн он хэмээн зарласан билээ.

Шинэ Монгол улсын засгийн газрын гадаад бодлогын эн тэргүүний зорилт нь төрийн тусгаар тогтнолоо бусад улс гүрнүүдээр юуны түрүүнд хоёр хөршөөрөө хүлээн зөвшөөрүүлэх, Ар, Өвөр Монголыг нэгтгэн үндэсний нэгдмэл улс байгуулахыг эрмэлзэж байв. Тийм дээрээс Монгол улсын Засгийн газар Герман, Англи, Франц, Бельги, Япон, АНУ, Дани, Нидерланд, Австри-Унгар зэрэг улсад ноот илгээж тусгаар тогтнолоо зарласан бичигтээ: “Их Фа, Ин, Дэ¹, Мэй, Билиш, Бин, Дан Ма, Хэ Лан, Ау улсын Гадаад хэргийн явдлын яамнаа илгээв, мэдтүгэй хэмээн явуулах учир: эдүгээ манай улсын засгийн газрын хэрэг шийтгэх газраас хүргэн ирсэн бичигт, эдүгээ манай Монгол улс нийт бүхнээр эртнээс тогтсоор ирсэн өөрийн газар орон ба шашин суртал, ёс журмыг алдахгүйгээр сахих учир нэгэнт Чин улсаас салаад өөртөө тогтнож өөртөө зээрхэх улс төр байгуулаад Халх Монголын шарын шашны эзэн Жавзандамба лам юугаан Монгол улсын эзэнд өргөмжилж, шашин, төрийг хослон бариулаад...зэрэг явдлыг эрхэм яамнаас олон улсад зарламуй хэмээн бичиг хүргэн ирвээс... мэдтүгэй хэмээн явуулан уламжлан Эрхэм Засгийн хэрэг шийтгэх газар нэвтрүүлэн байцаан үзэж хүлээгээд гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлж улсын найрамдлыг зузаатгана уу...” гэжээ².

¹ Дэ - гэдэг нь Герман гэсэн хятад ханзны дуудлага

² Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1900-1914), УБ, 1982, 61 дэх тал.

Хаант Монгол улсын ерөнхий сайд, сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй Засгийн газрын төлөөлөгчид Петербургт 1913 оны эцсээр хүрэлцэн очиж 1914 он гартал зочилсон байна. Ерөнхий сайд Намнансүрэн Оросын хаан II Николайд бараалхаж, Гадаад хэргийн сайд С.Д.Сазановтой биечлэн уулзаж байх зуур Өрнөдийн орнуудын элчин нартай холбоо тогтоон, тэдний зүгээс дэмжлэг олохыг оролдож Герман, АНУ, Англи, Франц, Японы Элчин сайдын яамдад ноот бичиг илгээж түүндээ Монгол улс тусгаар тогтнож, үндэсний нэгдмэл улс байгуулсан болохыг мэдэгдсэн ажээ. Тухайлан Германы Элчин сайдад Ерөнхий сайд Намнансүрэнгийн нэрээр явуулсан ноот бичиг доорх мэт байв. "Монголын засгийн газар Хятад ба Монголын харилцаанд хамаарах орос, хятадын мэдэгдэл ба дипломат бичиг сэлтийн зарим зүйлийн талаар үнэлэлтээ өгөх бүрэн эрхээ өөртөө хадгалах болно. Нэн ялангуяа хэзээ ямагт өөрт нь харьяалагдаж байсан газар нутгуудыг нэгтгэн авах болоод хэзээнээс Монгол улсад нэгдэн нийлж байсан бүх Монгол овогтныг багтаан харьяалж буй хилийг тийнхүү тогтоох эрхтэй болохоо нотлон илэрхийлж байна. Энэхүү тайлбартайгаар монголын засгийн газар дээр дурьдсан мэдэгдэл ба ноотод заан дурьдсан орос, хятад, монголын харилцаанд оролцоход бэлэн байгаагаа тунхаглан зарлаж байна"³ гэжээ. Гэвч ямар ч хариу авч чадаагүй тэрбээр гадаадын элчингүүдтэй уулзуулж Өрнөд Европын орнуудад очиход нь туслахыг Оросын ГЯЯ-наас хичээнгүйлэн хүссэн боловч тусыг эс олсон нь монголын асуудал нь нууц дипломат ажиллагааны үрээр хэдийнэ шийдэгдсэнтэй холбоотой байв.

Мөн үед 1913 онд гарсан Орос, Хятадын тунхаг, Германы худалдаа, аж үйлдвэрийн бүлгийнхний анхаарлыг татжээ. Германы үндэсний либерал намын удирдагч Фон Бассерман, 1861 оны Чин улстай байгуулсан гэрээ ёсоор Германы эзэнт улсын Монгол дахь худалдааны эрх ашигт Орос, Хятадын хэлэлцээр нөлөөлж байгаа эсэх тухай рейхстагт асуудал тавьжээ. Үүний хариуд гадаад хэргийн төрийн нарийн бичгийн дарга Фон Яговаас "Гадаад Монгол дахь Хятадын сюзеренитет эрхийг Орос, Хятадын сүүлчийн хэлэлцээрт заасан шиг тодорхой зөвшөөрөн хүлээгээгүй байсан ч 1861 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Германтай байгуулсан худалдааны гэрээ ба түүний дотор тогтоосон нэн тааламжтай нөхцлийн эрх нь хүчин төгөлдөр хэвээр байна"⁴ гэж илэрхийлжээ.

Герман нь Хятадаар дамжуулан Монголд худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа явуулж, тэнд Оросын капиталын нөлөөг сулруулахыг хичээж байв. Үүнийг 1914 оны 4 сард Хаант Оросын

³ В.Котвичийн хувийн архиваас олдсон Монголын түүхэнд холбогдох зарим бичиг УБ., 1972. 282 дахь тал.

⁴ Царская Россия и Монголия в 1913-1914 гг. "Красный архив" Т 6 (37) 1929 г.с.39

Сайд нарын танхимын дарга Горемыкинээс гадаад хэргийн сайд С.Д.Сазановт илгээсэн захидал гэрчлэх ажээ. Тэрбээр "Герман улсын идэвхитэй оролцоотойгоор Монголын зээлийг буй болгох, ерөөс Монгол оронд зонхилох байр сууриа бэхжүүлэх гэсэн Дундад улсын оролдлогын тухайд энэ 3 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн 17 тоот илтгэх хуудсыг хүлээн авав"⁵ гэжээ. Сайхь захидалд хавсаргасан бичигт өгүүлснээр "Хятадаас авах Монголын зээлийг Бээжинд суугаа Германы элчин сайдын хүчтэй дэмжлэгээр явуулж байна. Зээлийн гол шаардлага нь Хүрээнд Хятадын банкны салбарыг нээх явдал юм. Энэ нь хэрэг дээрээ Германы нууц хувийн банкны газар бололтой" хэмээжээ⁶.

Бээжин дэх Оросын элчингээс 1914 оны 3 дугаар сарын 27-нд Д.С.Сазановын нэр дээр явуулсан яаралтай мэдээнд Германы төлөөлөгчид Монголын асуудлыг ашиглан Хятадын дотор Оросын эсрэг явуулга хийж байгаа тухай дурьджээ. Оросын элчин В.Н.Крупенскийгээс бичсэн нь: "Хятадын Цэргийн Яамны герман зөвлөх хошууч Динкельман "Саяхан Монголын асуудал дээр бидэнд хийсэн буултыг эгүүлэн авахын тул Европ дахины гүрнүүд нийтээрээ хямралдаж буй зохистой үеийг ашиглахын чухлыг хятадуудад сурган заахдаа нэгээхэн ч тохиолдлыг алддаггүй байгаа нь өөрийн санаачлагаар гүйцэтгэж байгаа хэрэг биш бололтой гэж Юань Ши-Кайн дэргэд суугаа Францын цэргийн зөвлөх хурандаа Бриско-Демайль надад мэдэгдэв"⁷ гэжээ.

Өргөн уудам газар нутаг, байгалийн баялаг бүхий Монгол оронд борлуулалтын зах зээл, түүхий эдийн эх булагийн төлөө их гүрнүүдийн зөрчил тэмцэл ингэж тодорч байв. Германы тал Европт дайн гарсан тохиолдолд Монголыг хэрүүлийн алим болгон ашиглаж, Хятадыг Оросын эсрэг тавихыг эрмэлзэж байсан нь санамсаргүй хэрэг биш байжээ.

Энэ үед Монголын зах зээл дээр ийнхүү гадаадын капитал нэвтрэн орсоор байсан нь уламжлалт эдэлхүүний аж ахуйг задаргахад түлхэц өгч улмаар таваар-мөнгөний харилцааг хөгжүүлэхэд дэм болжээ. XIX зууны сүүл, ялангуяа XX зууны эхээр монгол орны эдийн засгийн амьдралд Их хүрээ, Хиагт, Улиастай, Ховд, зэрэг хотуудын гүйцэтгэх үүрэг мэдэгдэхүйц нэмэгдэж худалдаа, гүйлгээний хүрээнд үндэсний хөрөнгөлөг этгээдүүд буй болсон нь нийгмийн давхаргад гарсан шинэ үзэгдэл байлаа.

Нийслэл Хүрээ бол Монголын засаг, төр, шашин, эдийн засаг, худалдаа, соёлын гол төв байсан билээ. Их хүрээ гол төлөв бөөний

⁵ Международные отношения в эпоху империализма, Документы из архивов царского и временного правительств, 1878-1917. Серия 3-я т. II. Л., 1933 с.146

⁶ Мөн тэнд с.149

⁷ Мөн тэнд с.140

худалдаа явуулдаг Ховд, Улиастай хоёроос ялгаатай нь жижиглэн худалдаа ихэд дэлгэрчээ. Хүрээний зах зээл, дэлгүүр хоршоонд орос, хятадын бараа, таваараас гадна америк, филиппин янжуур, францын шампанск, герман, японы гоёл чимэглэлийн зүйлс өргөнөөр худалдаалагдаж байжээ. Хүрээнд Монголын бусад хотуудын адилаар хятадын пүүсүүд олонхи нь байсан бөгөөд мөнгө хүүлэх явдлыг өргөнөөр хэрэглэж байв.

Их Хүрээнд Оросын худалдааны пүүсүүдийн тоо ч хурдан олширч байв. Тухайн үеийн Их Хүрээний зах зээлийн байдлыг оросын худалдааны ангийнхан зураглан өгүүлэхдээ: “Олон сүрлэг хоршоо дэлгүүрийн зэрэгцээ... жижиглэн худалдаа их хийнэ, ер нь энд худалдааг төрөлжүүлэн хийж буйг ажиглаж болох юм. Нэг лангуун дээр өдөр тутмын хэрэгцээт зүйлс мах, ногоо, болсон будаа зэргийг дэлгэж, өөр лангуун дээр өдөр тутмын хэрэгцээт зүйлс, түүнээс цаашилбал төмөр эдлэл, бүр цаадах нь ангийн үс гэхчлэн наймаална. Эргэн тойрон олон хүн шахцалдаж үнэ хаялцах чимээ сонсогдоно”⁸ гэжээ.

И.Майскийн тодорхойлсноор, хувьсгалын өмнөх Ар Монголын бүх хүн ам жилд дунджаар 20 сая рублийн (1913 оны ханшаар) бараа худалдан авч байсан бөгөөд түүний дотор гадаадаас оруулж ирсэн бараа 18,8 сая буюу 94%, дотоодын бараа бүтээгдэхүүн 1,2 сая рубль буюу 6%-ийг эзэлж байжээ. Түүнчлэн гаднаас оруулж байсан барааны гуравны хоёр (61,7 %) орчим нь хүнсний (гурил, цай, саахар) зүйлс, дараа нь нэхмэл (15,7%) ба арьсан эдлэл (7%) орж байсан бөгөөд төмөр эдлэл дөнгөж 8 хувийг эзэлж байв⁹. Эндээс харахад тус орон гадаад орнуудаас эдийн засгийн талаар ихээхэн хамааралтай, импортын бараа нь бараг бүхэлдээ амины хэрэгцээний зүйлээс бүрдэж байсныг харуулж байна.

Энэ үеийн нэг онцлог бол Оросын худалдааны пүүс олширч мөн европ, америкийн капитал нэвтэрсэн нь улмаар Монголын зах зээлийг эзэмшсэн Хятадын худалдаа, мөнгө хүүлэх капиталтай өрсөлдөх томоохон хүчин зүйл болсоор байсанд оршино. Монголын зах зээлд чухам аль улсын капитал зонхилох нь тэрхүү капитал ар талдаа чухам ямар эдийн засагт суурилснаас шийдвэрлэгдэх ёстой байлаа. Хятадын худалдаа, мөнгө хүүлэх капитал хэдийгээр тухайн үедээ хөдлөшгүй бат бэх мэт харагдавч феодалын харилцаанд түшиглэж байсан болохоор нэгэнт ирээдүйгүй болсон байв. Хятадын капиталыг бодвол оросын худалдаа, үйлдвэрийн капитал нь өрсөлдөх чадвар илүүтэй байсан нь капиталист үйлдвэрлэлтэй холбоотой байснаар тайлбарлагдана. Хэдий тийм боловч Оросын капитал тухайн

⁸ Московская торговая экспедиция в Монголию 1910 г М., 1912 с.317.

⁹ Н.М.Майский. Монголия накануне революции, второе изд. М., 1959 с.61

үедээ тэргүүний техникт түшиглэсэн баруун европ-америкийн капиталын өмнө бас хүчин мөхөсдөж байжээ.

Монголын зах зээл дээр хүчирхэг өрсөлдөгч нь баруун европ-америкийн капитал байсан нь маргаангүй бөгөөд ялангуяа Германы капиталыг төлөөлсөн “Стукен энд Ко”, “Бидерман” зэрэг пүүсүүд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байв. Оросын худалдаачид сүүлийн үе хүртэл монгол ангийн үс, ялангуяа тарваганы арьсыг төдий л хүчтэй өрсөлдөөнгүйгээр бараг дангаар нь худалдан авч байсан нь алдагдахад хүрч, Германы Лейпцигийн пүүсүүдтэй тулгарах болов.

Герман, англи, америкийн худалдааны үйл ажиллагаа Монголоор түгж, хятад, оросын худалдааг шахаж байсны учир дээрхи улсууд үйлдвэрийн өндөр хөгжилтэй, бараа таваар нь хямд, хийц чанар сайтайгаас гадна усан замаар тээвэрлэхэд хямд байдгаар тайлбарлагдана. Үнэхээр ч Германы Ганбург, Английн Манчестер хотуудаас Тэнжин хүртэл усаар тээж тэндээс Монгол хүртэл хуурай замаар бараа авчрах нь Москвагаас Монгол хүртэл дан хуурай замаар бараа тээхтэй харьцуулбал үнийн хувьд бараг хоёр дахин хямд байжээ¹⁰. Монголоос түүхий эдийг Герман, Англи, Америк руу усаар зөөх нь мөн л тийм хямд байв. “Монголын ноосыг борлуулах гол газар бол Тэнжин мөн нь тодорхой билээ. Орон нутгийн ноосноос 1 сая 500 мянган пүү хүртэлхийг тэндээс жил бүр баруун европ, америкт гаргана” гэж “Вестник Азии” сэтгүүл 1911 онд тэмдэглэж байжээ¹¹.

Москвагийн худалдааны шинжилгээний ангийнхан Монголын ноосны арилжааны тухай судлан бичихдээ: Монголоос зөөх ноосыг Тэнжин, Хаалган зэрэг хотуудад Германы “Такеучи энд Ко”, “Мекензи энд Ко”, “Вальтер энд Ко” зэрэг пүүсүүд машинаар тээвэрлэн далайн чанадад зөөнө. Монголын хонины ноос Хаалган, Тэнжин руу их хэмжээтэй зөөгдөж тэндээс Англи, Америк руу гарна. Тэнжинээс бүх ноосны дөрөвний гурав хувь орчим нь Америкт, үлдсэн хэсэг нь Лондон, Ганбургийн зах зээл рүү тээвэрлэгдэнэ гэжээ. Монголын ноос мөн Тэнжинээр дамжих төдий бус Оросоор дамжин Баруун европт гарч байсан юм¹².

XX зууны эхний арван жилд бүс барааг Монгол, Хятадад гаргах талаар Англи, Япон, Герман улсын хооронд ширүүн өрсөлдөөн явагдаж Япон түрүүлж 55% эзэлж байсныг Москвагийн худалдааны ангийнхан тэмдэглэж байв¹³. Дурьдсан орнуудад хийсэн даалимба, цуу ямбуу зэрэг бүс бараа монголчуудын хувцас хунарт голлон хэрэглэгдэж байжээ.

Дэлхийн зах зээлд ангийн үс борлуулах талаар нэрд гарсан

¹⁰ Ш.Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа (1850-1919), тэргүүн дэвтэр УБ., 1971, 151 дэх тал

¹¹ Жур. “Вестник Азии” Харбин., №8, Февраля. 1911 с.152

¹² БНМАУ-ын түүх. 2-р боть, УБ., 1968. 266 дахь тал.

¹³ Московская торговая экспед...

Германы Лейпцигийн “Франц Меркер энд Герценштейн Ко”, “Дармштад Зиммермахер энд Виганд Ко”, Берлиний “Август Блюменталь энд Август Геннебюрк Ко” зэрэг томоохон пүүсүүд Монголын ангийн үсний ялангуяа тарваганы арьсны зах зээлтэй нягт холбоотой байжээ¹⁴.

Өөр нэг сонирхолтой чухал үзэгдэл бол Лондон ба Лейпцигт мөнгөний ханш буурах эсэх нь Монгол дахь ноосны үнийг хэлбэлзүүлэхэд нөлөө үзүүлж байсан явдал болно.

Энэ үед Монголын зах зээл дээр худалдаа, солилцооны гол эквивалентийн нэгжид эхлээд хонь, дараа нь цай хэрэглэгдэж байснаа таваар-мөнгөний харилцаа хөгжихийн хамт янз бүрийн хэрчмэл цагаан мөнгөн зоос, енбүү (юань бао), цаасан тэмдэгт хэрэглэж байв. Енбүүний зэрэгцээгээр Оросууд Германаас цагаан мөнгө худалдан авч Монголд нэвтрүүлдэг байжээ. Ганбургийн мөнгө буюу гулдмай цагаан гэж нэршсэн сайхь мөнгө нь чанарын хувьд шилдэгт орох боловч тухайлсан тодорхой хэлбэргүй заримдаа хэрчиж хэрэглэхэд зориулсан ховил зураас бүхий гонзгой дөрвөлжин хэлбэртэй ч байжээ. Ганбургийн дэнсний мөнгө нь енбүүтэй адил орон даяар дэлгэрээгүй гол төлөв Хаант Оросын худалдааны нөлөө илүү нэвтэрсэн Монголын баруун ба баруун хойд хошуу нутгаар хэрэглэгдэж байжээ. Удалгүй оросын цаасан рубль-цельков, хятадын янчаан (Луут, Юань Ши Кай-толгойт), мексик мөнгөн доллар (таягт) ба дэнсний лан мөнгө гүйлгээ, төлбөрийн хэрэгсэл болон ашиглагдах болжээ.¹⁵

ХИХ зууны сүүл ХХ зууны эхээр Түшээт хан, Сэцэн хан аймагт нээгдсэн олон улсын капитал “Монголор” хэмээх алтны уурхайн нийгэмлэгийг байгуулахад Германы “Мендельсон Ко” компани томоохон хувь нийлүүлж байжээ¹⁶. 1912 онд “Монголор” нийгэмлэгийн малтаж гаргасан 1 сая 354 мянган 222 рублийн үнэ бүхий алт оросоор дамжин Берлин, Амстердамд гарч байжээ.

1921 онд Монголд ардын хувьсгал ялж, шинэ Засгийн газраас дэлхийн улс түмэнд Монгол улс тусгаар тогтносон тухай зарлан тунхагласан нь Герман улсад ч мөн адил хандсан хэрэг байлаа. Тиймээс Монголд болсон хэрэг явдлыг тандах зорилгоор Бээжин дэх Германы ЭСЯ-ны худалдааны атташе, түүнчлэн Москва дахь Германы ЭСЯ-ны төлөөлөгч, Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийн нарийн бичгийн дарга нар Хүрээнд ирсэн тухай “Власть труда” сонины 1922 оны 8 дугаар сарын 19-ний дугаарт тэмдэглэсэн байна. Тэд Монголд төмрийн завод байгуулах боломжийн талаар Засгийн газарт санал тавьж байжээ¹⁷.

¹⁴ Мөн тэнд

¹⁵ А.Дамдинсүрэн Монгол мөнгө. УБ., 1975. 96 дахь тал

¹⁶ УТГА Ф. 382. Т. 3. ХН 51

¹⁷ Мөн тэнд

Архивын нэгэн баримтаар 1922 оны 2 дугаар сард Цэргийн яамны тэргүүн сайд Д.Сүхбаатараас цэргийн дүрэмт хувиасны даавуу, материал нийлүүлэх талаар Германы Хятад дахь салбар “Юэн Фунг Трейдинг энд Ко” компанитай гэрээ байгуулах талаар уг пүүсийн төлөөлөгч Гуго Мандель, Луппе Козумин нарт хандаж бичиг илгээсэн боловч Сангийн яаман дахь Зөвлөлт Оросын зөвлөх түшмэл Л.Я.Бутины хориглосон цохолт бүхий баримт байгаа нь нэн сонирхолтой юм.¹⁸

1920-иод онд Монголын нам, засгийн зарим удирдах зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй өрнөд европын зарим орнуудтай худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлийг барьж байжээ. 1923 оны 6-р сарын 24-нд тусгай комиссоос боловсруулан нийтэлсэн “Эдийн засгийн үндсэн бодлого”¹⁹ хэмээх Засгийн газрын бодлогын шинж чанартай баримт бичиг бол түүний тод илрэл юм.

Тухайлбал тэрхүү баримт бичгийн 17 дугаар зүйлд “Монгол улсын гадаад худалдааны учир байцаавал Орос, Рибин, Америк, Англи, Герман зэргийн олон их, бага улс дотроос зарим нь хурц эрдэмтэй, зарим нь бүдүүлэг байх мэт чанар дүрс адилгүй учраас зүй нь харилцан худалдаа, ашиг, эрдэм, соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрүүлэхэд хүрвэл эрх биш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн шилж сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орох буй заа” гэжээ.²⁰ Энэ баримт бичгийг 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАХН-ын II их хурлаас намын Программд нэмэн өргөтгөж баталсан 9 дүгээр зүйлтэй адил сацуугаар улс төрийн ба намын хэрэгт удирдлага болговол зохино гэжээ.²¹

Үүнтэй холбогдуулан архивын бас нэгэн шинэ баримт бол 1926 оны 1 дүгээр сард БНМАУ-ын ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Аж ахуйн явдлын яамны сайд А.Амар, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч гишүүн бөгөөд Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Н.Жадамбаа нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид ЗХУ-д томилогдон очиж, тус хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлаар зөвлөлтийн зохих хүмүүстэй хэлэлцээ хийсэн байна. Төлөөлөгчид ЗХУ-д сар гаруй хугацаагаар байхдаа БНМАУ-ын Засгийн газрын саналыг албан захидлын хэлбэрээр бичиж ЗХУ-ын Гадаад хэргийн ардын комиссар Г.В.Чичеринд гардуулан өгч зохих хариу авчээ.

¹⁸ НТА. Ф. 12. Т. 1. ХН 69

¹⁹ УТГА. Лавлах номын сан. З/2330-ын 7-9 дэх тал, хэвлэмээс

²⁰ Мөн тэнд

²¹ Б.Лхамсүрэн. Из истории внешних сношений Монгольской Народной Республики (1921-1945 гг.), “Современная Монголия”, 1957. № 6, с.24

Дурьдсан бичигт: “Үүнд эдийн засгийн тухай хэргийг улс төрийн хэрэгт холбогдуулалгүй хэлэлцэж үл болох тухай явдлыг эрхэм Танаа сануулах юун, Тийм хэмээвч эл сайжруулах тухай хүсэх зүйлийг гаргахын урьд улс төрийн нийтийн явдалд холбогдох нэгэн чухал зүйлд, бид санаваас алив үл нийлэлцэх хэргүүдийн их төлөв нь нийт улс төрийн тухайд холбогдох зүйлүүдэд хоёр этгээдээс зөвшөөрөлдөн бодол, санааг нэгтгэсэнгүйгээс үүссэн ба үүсч буйгаас өөр, хоёр этгээдийн албаны хүмүүсийн хувийн санал явдал зэргээс болсон газаргүй мэт... Ихээхэн чухал болох зүйл нь худалдаа болно. Нэг. Монгол улс ба мөн улсын худалдааны газрууд болбоос харьяат улсын түүхий эдийг хаана үлэмжхэн их үнэ хүргэж болох газраа нэвтрүүлэх ба гадаадаас авч ирэх барааг аль улсад боловсруулсныг хэрэгсэхгүй, гагцхүү чанар сайн, үнэ бага агаад харьяат олон ардын хэрэглэх, дурлах явдалд тавтайяа нийцүүлэхийг нь сонгон бэлтгэж авч ирнэ. Оросын аж ахуйн газруудаас эл манай худалдааны бодлогод саад боогдол учруулж устгахыг хичээх нь олон ардын туйлын ашиг тус ба манай хувьсгалт улсын аливааг үйлдэх боловсруулах хэрэг явдалд их л хор болно...Хоёр. 1. Монгол газар худалдаалах оросын аж ахуйн газрууд бол одоо чөлөө бүхийгээр тэмцэлдэн худалдаалах худалдааны журмыг хүндэтгэн явуулбаас зохих, Үүнд 1925 онд оросын худалдааны газруудаас түүхий эдийн үнийг хомстгож тогтоохоор завдсантай адил хэрхэвч монголын түүхий эдийн үнийг алив арга хэрэглэн хомстгохгүй ба Монголд нэвтрүүлэх эд барааны үнийг мөн тэрчлэн хэтэрхий болгохгүй, бас алив нэг түүхий эдийн үнэ буурах цагуудыг хэрэглэж хэтэрхий боогдуулахгүй, жич гадагш нэвтрүүлэх ба гаднаас ирэх эд барааны төлөвлөлийг Монголын зохих газруудтай нийлүүлэн явуулж алив эд барааг хэтэрхий ихээр буюу хэтэрхий хомсоор оруулах явдлыг үл үүсгэвээс зохих болов уу. 2. Холбоот улсад Монголын аж ахуйн газрууд, ялангуяа Монгол хоршоог саадгүй худалдаалах явдлыг тогтоон гүйцэтгэвээс зүйтэй мэт. 3. Холбоот улсын харьяат газрууд зарим нэгэн зүйлийг Монгол газар худалдаалах явдлыг онц эрх болгон явуулж буй нь мөн зүйлийн барааг Монгол газар элбэгээр дэлгэрүүлэх ба чөлөө бүхийгээр тэмцэлдэн (өрсөлдөөн Д.У) үнийг бага болгох явдалд саад болж буйг нь устгаваас зохих болов уу” гэжээ.²²

Хэдийгээр ЗХУ болон Коминтерны зүгээс БНМАУ-ын дотоод, гадаад бодлогыг өөрийн чиг шугамд захируулах ажиллагаа газар авсаар байсан боловч үндэсний эрх ашгаа дээдлэх үзэл санаа Монголын улс төрийн зарим зүтгэлтнүүдэд 1920-иод оны хувьд хүчтэй хэвээр байжээ. Тухайлбал, 1924 онд Монголоос ЗХУ-д суух бүрэн эрхт төлөөлөгчөөр томилогдсон Б.Данзанд ГЯЯ-наас өгсөн удирдамж

²² УТТА. Ф. 172. Т.5. ХН 98

юм. Түүнд ЗХУ-тай харилцаагаа хөгжүүлэхийн зэрэгцээ Герман зэрэг гадаад улсуудад биеэр очиж тэндэхийн улс төрийн байдал, худалдааны харилцаа тогтоох боломж, Монголыг хэрхэн үзэж байгаа хэргийг судалж монголч эрдэмтэдтэй уулзаж, ном зохиолоос нь олж ирүүлэх үүрэг өгч байсан байна.²³ Цаашилбал ЗХУ-аас бусад гадаад орнуудтай найрсаг харилцаа тогтоон хөгжүүлэх тухай заалт Москвад сууж байсан Монголын Бүрэн Эрхт Төлөөлөгчийн газрын 1926 оны дүрэм болон ГЯЯ-ны 1927 оны дүрэмд²⁴ бас орсон байна. Ингэж 1925 оноос Германтай нилээд дэлгэр харилцаатай болж, Монголын худалдааны төлөөлөгч 1929 он хүртэл Берлинд ажиллаж байжээ. МАХН-Төв Хорооны дарга Ц.Дамбадорж, нарийн бичгийн дарга Н.Жадамбаа нар 1926 онд Герман, Франц зэрэг орнуудаар явж тэдгээр улсуудтай холбоо тогтоох зорилготой байжээ. Гэвч энэ айлчлалын талаархи баримт тун хомс байдаг нь ЗХУ-аас нууж айлчилсантай холбоотой байж мэдэх юм. Юутай ч тэд Германд худалдааны төлөөлөгч очуулах, Герман, Францад хүн сургах, Монголын аж ахуйн хөгжилд Германы тусламж авах, тэндээс мэргэжилтэн урьж авчирч ажиллуулах, худалдааг хөгжүүлэх зэргийг тохирсон байна. Ийнхүү Герман нь ЗХУ-аас гадна найрсагаар харилцсан БНМАУ-ын хоёр дахь улс болсон гэж үзэж болохоор юм.

Дараах онуудад Германы тусламжтайгаар Монголд тоосгон завод, анхны жижиг цахилгаан станц, төмрийн завод зэрэг үйлдвэр буй болж Герман мэргэжилтэн урилгаар ирж ажиллах болсноос гадна Германы Геологийн шинжилгээний ангийнхан ирж хайгуул судалгааны ажил хийж байв. Германы АЕГ пүүсээс худалдаж авсан 500 квт чадалтай цахилгаан станц нь Монголдоо анхных нь байжээ.²⁵ 1925 онд анхны 25 хүүхдийг Германд сургуульд явуулсан ба тэд Лейпциг, Берлин зэрэг хотуудад айлаар амьдран дунд сургуульд сурч байжээ. Төлбөрийг нь Монголын засгийн газар хариуцаж байсны дээр Герман, Францад сурч байсан сурагчдын монгол захиргаа байгуулагдаж даргаар нь Ишдорж ажиллаж байв. Эдний дунд их зохиолч Д.Нацагдорж суралцахын зэрэгцээ Монголын худалдааны төлөөлөгчийн газарт хэлмэрчилж байжээ. Суралцагсдын тоо дараагийн элсэлтээр 44 хүрсэн байна. Францад 1925-1926 онд Ленинградын Дорно дахины дээд сургуульд суралцаж байсан Мэргэн хэмээх Гомбожав проф.Ж.Цэвээний эхнэр Бадамжавын хамт Монголын Шинжлэх ухааны хүрээлэнгийн томилолтоор Парис хотод очиж тэр үеийн дэлхий дахинд нэртэй францын монголч эрдэмтэн П.Пеллиог дагалдан 1927-1929 оны хооронд ажиллажээ. Тэгж явахад

²³ ГХТА. Ф. 01ш. 1173

²⁴ ГХТА. Ф. 01 ХН 274

²⁵ Friters D. Outer Mongolia and Its International Positions. London, 1951, p. 89

нь Берлин хотноо М.Гомбожавтай уулзаж байсан эрдэмтэн С.Вольф хожим тэдний тухай дурсан бичихдээ “тэр хоёр хоёулаа ихээхэн ухаантай, сонирхолтой, сайхан хүмүүс байв...Гомбожав биеэ авч явах байдал, оюун ухаан, ялдам сайхан зангаараа асар их сэтгэгдэл төрүүлж билээ” гэжээ.²⁶

Германд сурч байсан сурагчдыг эргэж тойрохоор 1927 онд Москвад элчин төлөөлөгчөөр ажиллаж байсан Ганжуурын Гүрсэд хэлмэрч Бат-Очирын хамт очиж мөн үеэр Германы ГЯЯ-ны дорно дахины асуудал хариудсан ажилтнуудтай уулзаж, өөрийн сурагч нараа захиж байжээ.²⁷ Түүнчлэн 1928 онд Гэгээрлийн Яамны сайд Эрдэнэ-Батхаан мөн Германд сурч байсан сурагчдаа эргэж иржээ.²⁸

1926 оны сүүлчээр Хаалган хот дахь Америкийн консул болсон Л.Кларк Төрийн департаментдаа мэдээлэхдээ: Монголчууд большевик зөвлөгч нартаа сэтгэл алдарч, германчуудаар солих төлөвтэй байна, тэд залуучуудаа Германд явуулан сургах төлөвтэй байна. Хэрэв энэ явдал бүтэмжтэй болбол Монголд гадаадын худалдаа дахин чөлөөтэй нэвтрэн дэлгэрэх болно гэж байв.²⁹ Гэвч Герман болон Францад сурч байсан сурагч, оюутнуудыг олон улсын байдал болон Коминтернийн шахалтаар гэдрэг буцаажээ.

1920-иод оны үед Монголд Германы 5 орчим пүүс худалдааны үйл ажиллагаа явуулж байсны дээр Монголын Хариуцан Тусалцах Хоршоо /МХТХ/ Германтай худалдаа хийж, 1925, 1926 онд нийт 4 сая 114 мянга 400 төгрөгийн барааг худалдан авчээ.³⁰

Монголын зах зээл дээр 1927 оны байдлаар МХТХ болон гадаадын компаниудын худалдаа хосолж, тэдгээрийн 19 сая 353 мянга гаруй мексик доллар гүйлгээнд эргэлдэж байв. Үүнийг улс тус бүрээр авч үзвэл МХТХ 3 сая 900 мянган мексик доллар, Монголын Худалдаа, Аж үйлдвэрийн банк (хувь нийлүүлсэн үндсэн хөрөнгө оролцохгүйгээр) 1 сая 267 мянган мексик доллар, Оросын харьяат хувийн худалдаачдын 46 пүүсийн 704 500 мексик доллар буюу нийт дүнгээрээ 1 сая 971 500 мексик доллар болж байв.

Хятадын худалдаачдын 283 пүүсийн зах зээлийн нийт эргэлт нь 7 сая 248 000 мексик доллар, Английн худалдааны 10 пүүсийн 4 сая 500 500 мексик доллар, Америкийн 5 пүүсийн 560 000 мексик доллар, Германы 6 пүүсийн 173 000 мексик доллар буюу гадаадын бүх капитал нийт дүнгээрээ 12 сая 448 000 мексик долларт хүрч

²⁶ “Мэргэн хэмээх Гомбожав” Улаанбаатарын мэдээ сонин. 1988.12.15. №40

²⁷ А.Думбарай “Ганжуурын Гүрсэд” Залуучуудын үнэн, 1989.08.25 №4

²⁸ Friters D. Outer Mongolia and Its International Positions. London, 1951, p. 104

²⁹ Campi A.J. “Receptions of the Outer Mongols by the United States government as reflected in Kalgan (Inner Mongolia) US. Consular records 1920-1927.” Mongolian Studies, Vol. XIV, year 1992 p.97
1926 оны Улсын II их хурлын илтгэлд Герман, Орос, Англи, Америк, Дани, Франц, Польш, Унгар, Италийн харьяат 2700 хүн бүртгэгдсэн гэжээ.

³⁰ М.Пэлжээ. БНМАУ дахь таваарын үйлдвэрлэл ба худалдаа. УБ., 1964, 34 тал

байсан нь тус улсын гүйлгээний 66,1 хувийг эзэлж байсан байна.³¹

МХТХ-ноос санаачлан зохион байгуулсан БНМАУ-ын анхдугаар Яармаг худалдааг 1927 оны 7 дугаар сард Улаанбаатарт нээжээ. Яармаг худалдаанд МХТХ, Монголын Худалдаа, Аж үйлдвэрийн банк, тээх нэвтрүүлэх “Булигаарын завод” зэрэг газрууд оролцсоны гадна Зөвлөлтийн худалдааны 3 салбар, хятадын 81 пүүс, дотоодын хувийн худалдаачид 20, Англи, Америкийн худалдаачид 6, Германы 5, бүгд 142 газар оролцжээ. Анхдугаар Яармагаар 600 000 төгрөгийн барааг нээн ажиллуулж 150 000 төгрөгийн түүхий эд худалдан авч, 321, 2 мянган төгрөгийн гүйлгээ хийжээ.³² Харамсалтай нь “Баруунтныг” илчлэх зүүнтний үйл ажиллагааны улмаас 1928 оны 7 дугаар сард Хэнтий аймагт болсон 2 дахь Яармаг худалдаанд Герман, Англи, Америкийн компаниуд оролцож чадаагүй юм.

Коминтерн болон зүүнтний ажил явуулгын үрээр Монгол Улсын Засгийн газар 1930 оны 12 дугаар сард гадаад худалдаанд улсын онц эрх тогтсоноор Монгол улсын эдийн засаг дан ганц нэг орноос хамааралтай болохын үндэс тавигджээ. Гадаад худалдаанд улсын онц эрх тогтсоноор гадаадын компаниуд үйл ажиллагаа явуулах бололцоогүй болж, Монголын эдийн засгаас шахагдан гарчээ.

Харин ЗХУ-д үйлдвэрлэдэггүй машин, тоног төхөөрөмж болон аж үйлдвэрийн бусад бараа, бүтээгдэхүүнийг гурав дахь зах зээлээс нийлүүлэх зорилгоор ганцхан Германы томоохон монопольт компани “Остваг”-ийн Монголд явуулж байсан үйл ажиллагааг нь үргэлжлүүлэхээр зөвшөөрсөн байна.

“Остваг” компани 1922 оноос Монголд үйл ажиллагаагаа эхэлж, монголоос мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, эрдэс түүхий эдийг импортоор авч, машин тоног төхөөрөмж нийлүүлж байв. 1923 оноос 100 гаруй авто хөсгөөр Хаалган, Нийслэл Хүрээний хооронд байнгын ачаа, тээврийн үйл ажиллагаа явуулж эхэлжээ.³³

1930 оноос “Остваг” компани БНМАУ-ын Засгийн газрын зөвшөөрлөөр Улаанбаатарт ажиллаж, Хоршоодын төв Холбоо, Улсын худалдааны газрын хамтран боловсруулж, Худалдаа, Аж үйлдвэр, Тээвэр харилцан нэвтрэлцэх Холбооны яамаар батлагдсан захиалгын дагуу бараа бүтээгдэхүүнийг нийлүүлж байв. “Остваг” компани Монголд оруулж ирэх өөрийн барааг үндсэнд нь хоёр чиглэлээр бэлтгэж байжээ. Үүнд: Герман ба Европын бусад орнуудаас автомашин, түүний сэлбэг хэрэгсэл, унадаг дугуй, бичгийн машин, цаг, цахилгаан хэрэгсэл, бэлэн хувцас болон бусад жижиг бараа, Хятадад бэлтгэсэн торгон нэхмэл, үхрийн булигар, илэг, сарьс, гөлөм

³¹ УТГА. Ф. 91. Т. 27. ХН 13

³² “Үнэн” сонин 1927. №4

³³ Motor Deal with Living God in Urga. “Asia”, 1924. Vol. 31. pp. 232-338

дэвс, ташуур, цай, тамхийг Зөвлөлт, Хятадын нутгаар дамжуулан нийлүүлж байв. Энэ компани Монголоос тарвага, үнэг, чоно, хэрэм, хярсны арьс зэрэг ангийн үс голлон бугын эвэр, мөөг, хунчир, мөн ноос зэрэг бусад түүхий эдийг бага хэмжээгээр гаргаж байжээ.³⁴ “Остваг” компанийн Хятад болон Баруун Европт бэлтгэн оруулж ирсэн бараа 1933 онд хилийн үнээр 1920, 4 мянган алтан рубль буюу жижиглэн худалдаалах үнээр 7622,2 мянган төгрөг байсан бол 1935-1938 онд хилийн үнээр 3643,9 мянган алтан рубль буюу жижиглэн худалдаалах үнээр 364 334,7 мянган төгрөгийн барааг оруулж ирж байв.³⁵ “Остваг” компани Хятадын Нанжоу-Юшань-Наньчан-Писян-Чужоу чиглэлээр төмөр зам тавьж байсан Германы нэртэй томоохон компани болох “Отто Вольф энд Ко”, “Фенштейн, Оппель, Ферресталь, Фридрих Групп”, “Сталь юнион экспорт Ко” зэрэгтэй нягт хамтран ажиллаж байсан юм. Германд фашист дэглэм тогтож, олон улсын байдал хурцадсаны улмаас 1938 онд Сангийн Яамны сайд Ю.Цэдэнбалын тушаалаар “Остваг” компанийн Монголд явуулж байсан үйл ажиллагааг нь зогсоожээ.

Эцэст нь тэмдэглэхэд XIX зууны сүүлч XX зууны эхээр Германы Алс дорнод дахь ашиг сонирхол буй болж улмаар Монголд ч анхаарал тавьж эхэлжээ. Хоёр орны түрүү үеийн харилцааны түүхийн хамгийн оргил үе нь 1920-иод он байсан нь тодорхой юм. Тухайн үедээ Герман нь Монгол Улсын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөөгүй хэдий боловч манай улстай ЗХУ-ын дараа сайн харилцаатай байсан хоёр дахь улс байсан гэж үзэж болно. Энэ нь Монгол-Герман хоёр улсын хожмын найрсаг харилцаа хөгжихийн шимтэй хөрс болсон нь маргаангүй билээ.

³⁴ Жур. “Хозяйства Монголии” 1928, №4

³⁵ УТТА. Ф. 289. (Остваг компанийн үйл ажиллагааны тайлан, үдмэл хавтас)